



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/330

Хэрлэн сум

Ёслолын үйл ажиллагаанд зориулж
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 60 дугаар зүйлийн 60.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах баярыг тохиолдуулан “Алдарт эхийн 1, 2 дугаар одон” гардуулах ёслолын үйл ажиллагаанд зориулж 4,152,000 (дөрвөн сая нэг зуун тавин хоёр мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн
А/330 дугаар албан бичгийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Сарнай цэцэг	346ш	12,000	4,152,000
	Нийт			4,152,000